



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/517

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 137
дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,108,800.0 (дөрвөн сая нэг зуун найман мянга найман зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 137 дугаар сургууль (Ц.Буйданбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн 1,863,500.0 (нэг сая найман зуун жаран гурван мянга таван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 3 нэр төрлийн 2,245,300.0 (хоёр сая хоёр зуун дөчин таван мянга гурван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 137 дугаар сургууль (Ц.Буйданбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501591

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/57 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 137-р сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ын мэргэжилтний үнийн санал	ЭБХХХК-ын хурлын шийдвэр
1	Зөөврийн компьютер dell	8	ш	1	748,000.0	748,000.0	748,000.00	-	ашиглалтын шаардлага хангахгүй	актлах	устгах	устгах	устгах
2	Зөөврийн компьютер hp	8	ш	1	924,000.0	924,000.0	924,000.00	-		актлах	устгах	татах	татах
3	Зөөврийн компьютер dell	8	ш	1	748,000.0	748,000.0	748,000.00	-		актлах	устгах	татах	татах
4	Буузны жигнүүр	8	ш	1	573,300.0	573,300.0	573,300.00	-		актлах	устгах	татах	татах
5	Ус буцалгагч	8	ш	1	201,000.0	201,000.0	201,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
6	Хөргөгч	8	ш	1	664,500.0	664,500.0	664,500.00	-		актлах	устгах	устгах	устгах
7	Телевизор samsung	8	ш		250,000.0	250,000.0	250,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
	Тоног төхөөрөмжийн дүн				4,108,800.0	4,108,800.0	4,108,800.00	-			-	-	-
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					4,108,800.0	4,108,800.0				-		
Үүнээс: Худалдах хөрөнгө													
Устгах хөрөнгө													
								4					
Татан төвлөрүүлэх хөрөнгө								3					